

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

УДИРТГАЛ

Үндэслэл:

Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл ихээхэн хийгдэн шинэ дэвшилтэт техник, технологи хурдацтай нэвтэрч байгаагийн хэрээр оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжүүдийн бүтэц, зохион байгуулалт улам бүр нарийсаж байгаа тул тоног төхөөрөмжүүдийн хэвийн найдвартай үйл ажиллагааг ханган ажиллах мөн түүний засвар үйлчилгээг тогтмол хийж байх шаардлага тулгарч байна.

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг өндөрт өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хэрхэн хийгдэж байгаа талаар судалгаа хийж, засвар үйлчилгээний хэрэгцээг тодорхойлсноор оношилгоо, эмчилгээний өндөр үр ашигтай тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тогтмол ханган ажиллахад тулгамдаж буй нөхцөл байдлыг судалснаар хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралгүй хэвийн, найдвартай явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болох ач холбогдолтой.

2015 онд хийсэн нийслэлийн болон орон нутгийн төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаанаас нэгдсэн мэдээлэл болон түүний хэдэн хувь гэмтэлтэй байгааг нь тодорхойлсон.

Харин энэхүү судалгаагаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж буй өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн хугацаат техник үйлчилгээ болон засвар үйлчилгээний гүйцэтгэл, засвар үйлчилгээнд жил хэдэн төгрөг зарцуулдаг мөн тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлно.

Зорилго:

Эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж буй өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг судлах.

Зорилт:

- Эрүүл мэндийн байгууллагуудын өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварын ажлыг хэрхэн гүйцэтгэж байгаа талаар мэдээлэл цуглуулах;
- Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийхэд тулгамдаж буй асуудал;
- Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийг засварлахад цаашид анхаарах зүйлс;

Судалгааны ажлын аргачлал

- Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмж гэж юуг хэлэх тухай тодорхойлолт - Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмж гэдэгт нь гуравдугаар шатлалд ашиглаж байгаа 100,0 саяас дээш өртөгтэй, хоёрдугаар шатлалд 50,0 саяас дээш өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмж орно.
- Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох 30 асуумж бүхий судалгааны маягтыг боловсруулж, маягтын дагуу тухай эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер болон хариуцсан мэргэжилтнээс судалгаа авах
- Судалгааг албан бичгийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, мэдээллийг маягтын дагуу цуглуулсан.

ХҮСНЭГТ 1. СУДАЛГААНЫ АСУУМЖ

№	Эмнэлгийн нэр		
1	Тоног төхөөрөмжийн нэр		
2	Марк модель		
3	Серийн дугаар		
4	Үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгчийн нэр		
5	Үйлдвэрлэсэн он		
6	Ашиглалтад орсон он		
7	Ашиглалтад орохдоо шинэ байсан эсэх	Тийм	Үгүй
8	Үнэ		
9	Эх үүсвэр		
10	Ханган нийлүүлэгч		

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

11	Нийлүүлэгдсэнээс хойш баталгаат засварын хугацаа		
12	Засвар үйлчилгээг хариуцан ажилладаг эсэх	Тийм	Үгүй
13	Засвар үйлчилгээгээ хариуцан ажилладаг бол тухайн инженер техникч нар сургалтад хамрагдсан эсэх		
14	Засвар үйлчилгээг бие даан хийх боломжтой	Тийм	Үгүй
15	Гэрээт засварын үйлчилгээ авдаг эсэх	Тийм	Үгүй
16	Гэрээт засварын үйлчилгээ авдаг байгууллага		
17	Гэрээний нөхцөл		
	Бүрэн засвар	Жижиг засвар	
	Эргэлт үйлчилгээ	Хугацаат сэлбэг	
18	Хугацаат сэлбэг хэрэгслийг байнга сольдог эсэх	Тийм	Үгүй
19	Тогтмол хугацаанд солигддог сэлбэгийн нэр	Тоо ширхэг	Үнэ
	Нийт		
20	Гэрээт засвар болон сэлбэг хэрэгслийн зардлыг жил бүрийн төсөвт тусгадаг эсэх	Тийм	Үгүй
21	Тусгасан төсвөө тогтмол авдаг эсэх	Тийм	Үгүй
22	Гэрээт засвар болон сэлбэг хэрэгслийн зардлыг бусад эх үүсгэврээс авдаг бол		
	Нийлүүлэгдсэнээс хойш уг тоног төхөөрөмжид гарсан гэмтлүүд	Засвар үйлчилгээнд зарцуулсан зардал	
	Нийт		
23	Дээрх зардлыг төлсөн эх үүсгэвэр		
24	Гарсан гэмтлийг одоо хүртэл засварлаагүй байгаа шалтгаан		
25	Уг тоног төхөөрөмжийг ажилд оруулснаар гарах ач холбогдол		
26	Өдөрт ажилладаг цаг		
27	Өдөрт хэдэн хүн үзүүлдэг		
29	Сүүлийн жилийн хугацаанд үзүүлсэн хүний тоо		
30	Нийт ажилласан цаг		

Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааны үр дүн

Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын судалгааны, аргачлалыг боловсруулан ЭМХТ-ийн захирлаар батлуулж, 2016.06.16-ны өдрийн 670 дугаартай албан тоотоор эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн 2016.06.30-ний өдөр эрүүл мэндийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг маягтын дагуу цуглуулсан.

Судалгаанд нийт 43 эрүүл мэндийн байгууллага оролцон, 330 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг ирүүлсэн байна. Үүнээс:

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

1. Гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага буюу зуун сая төгрөгөөс дээш үнэтэй 163 ширхэг
2. Хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага буюу тавин сая төгрөгөөс дээш үнэтэй 167 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг тус тус ирүүлсэн байна.

ХҮСНЭГТ 2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА

Д/д	Байгууллагуудын ангилал	Тоо ширхэг
1	Клиникийн нарийн мэргэжлийн төв, төрөлжсөн нарийн мэргэжлийн төв	13
2	Дүүргийн нэгдсэн эмнэлэг	10
3	Амаржих газар	3
4	Аймгийн нэгдсэн эмнэлэг	13
5	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	4
Нийт		43


Судалгаанд тавигдсан шаардлагын дагуу “Өндөр өртөгтэй тоног төхөөрөмж”-д багтаж асуумжийн дагуу мэдээлэл цуглуулсан тоног төхөөрөмжийг нэр төрлөөр нь ангилбал Гемодиализын аппарат, гемодиализын үс цэвэршүүлэгч 13, Наркозын аппарат 16, Компьютер томограф 14, Лабораторийн тоног төхөөрөмж 58 /PCR, ELIZA, Генетикийн анализатор /genetic analyser/, нян судлалын анализатор, биохимийн, иммунологийн, шээсний шинжилгээний, гемотлогийн бүрэн автомат анализаторууд/, Соронзон Резонанс Томограф 4, Оношилгоо, эмчилгээний дуран 50, Рентген аппарат 55, Флюрографийн аппарат 15, Маммографийн аппарат 5, Ангиографийн аппарат 4, Хэт авиан оношлогооны аппарат 69, Амьсгалын аппарат 9, бусад 18 гэсэн аппаратууд байна.



Судалгаанд хамрагдсан нийт 330 эмнэлгийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэсэн огноогоор нь авч үзвэл:


- 2008 оноос өмнө үйлдвэрлэгдсэн 45,
- 2009-2010 онд 21,
- 2011-2012 онд 50,
- 2013 онд 92, 2014 онд 50,
- 2015 онд үйлдвэрлэсэн 72 тоног төхөөрөмж байна

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА



Нийт 330 тоног төхөөрөмжийн 18 хувь нь 2010 оноос өмнө үйлдвэрлэгдсэн байна
Ашиглалтад орсон оноор нь ангилбал:

- 2008 оноос өмнө 30,
- 2009-2010 онд 25,
- 2011-2012 онд 44,
- 2013 онд 39,
- 2014 онд 104,
- 2015 онд 62,
- 2016 онд 26 тоног төхөөрөмж




Үйлдвэрлэсэн улсаар нь ангилбал

- БНСУ - 60,
- Хятад 25,
- Герман 50,
- Япон 113,
- Бусад улс 72 /Австри, АНУ, ОХУ, Канад, Франц, Голланд, Итали/
ширхэг аппарат тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгдсэн байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Үүнээс үзэхэд манай орд ашиглагдаж байгаа өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн 54%-ийг Япон, Солонгос улсад үйлдвэрлэсэн байна.



Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээгээ хариуцан ажилладаг инженер техникч нар тухайн тоног төхөөрөмж дээр сургалтад хамрагдсан эсэх дээр сургалтад хамрагдсан 101, сургалтад хамрагдаагүй 217, тоног төхөөрөмжийн инженергүй 14 өндөр өртөгтэй тоног төхөөрөмж байна. Нийт тоног төхөөрөмжийн 65 хувьд нь сургалт хийгээгүйгээс үзэхэд ханган нийлүүлэгч нь тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний сургалтыг хангалтгүй хийж байна.


Санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал төсөл, олон улсын байгууллагын санхүүжилтээр 74, улсын төсвөөс 204, гадаад болон дотоодын хандив тусламжаар 52 тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.



Нийт тоног төхөөрөмжийн 62 хувь нь улсын төсвөөс санхүүжигдсэн байна.

Судалгаанд хамрагдсан нийт 330 өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн 308 ширхэг тоног төхөөрөмжид бие даан засвар үйлчилгээг хийх боломжтой, 22 ширхэг аппарат, тоног төхөөрөмжид эрүүл мэндийн байгууллагын инженер, техникч нар бие даан засвар үйлчилгээг хийх боломжгүй байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА




Засвар үйлчилгээг бие даан хийх боломжгүй тоног төхөөрөмжүүдэд Видео бронхоскопи, Лапроскопи, Соронзон Резонанс Томограф, PCR, лабораторийн бүрэн автомат анализатор гэх мэт тоног төхөөрөмжүүд байна.

Судалгаанд хамрагдсан нийт өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн 171 ширхэг тоног төхөөрөмж нь гэрээт засвар үйлчилгээг авдаг үлдсэн 159 нь гэрээт засвар үйлчилгээ авалгүй ажилладаг байна.




ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

Өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн 171 ширхэг нь гэрээт засвар үйлчилгээг авдаг байна. Засвар үйлчилгээний гэрээний нөхцөл нь гэрээт ажилтнаар засвар үйлчилгээг хийлгэдэг 1, жижиг болон урсгал засвар үйлчилгээг авдаг 35, эргэлт үйлчилгээ болон хугацаат сэлбэг авдаг 23, бүрэн засвар үйлчилгээ хийлгэх гэрээтэй ажилладаг 112 ширхэг өндөр өртөгтэй эмнэлгийн тоног төхөөрөмж байна.



Судалгаанд хамрагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн 54% /180/ нь гэрээт засвар үйлчилгээ болон сэлбэг хэрэгслийн зардлыг жил бүрийн төсөвт тусгадаг, 46% /152/ нь гэрээт засвар үйлчилгээ болон сэлбэг хэрэгслийн зардлыг жил бүрийн төсөвт тусгадаггүй байна. Гэрээт засвар үйлчилгээ болон сэлбэг хэрэгслийн зардлыг жил бүрийн төсөвт тусгадаг 180 тоног төхөөрөмжийн 20% нь жил бүрийн засварын зардлаа тогтмол авч чаддаг байна.



Судалгаанд 23 нэр төрлийн 70 гаруй тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 330 эмнэлгийн тоног төхөөрөмжийн ирснээс 8 тэрбум гаруй үнийн дүнтэй 42 тоног төхөөрөмжид 987,783,000.00₮-ийн засварыг хийсэн байна. Үүнээс улсын төсвөөс 706,730,000.00₮, байгууллагын зардлаар 277,053,000.00₮, баталгаат засвар хугацааны зардлаас 4,000,000.00₮-ийг зардлыг тус тус төлсөн байна. Тогтмол хугацаанд хугацаанд сэлбэг хэрэгслээ сольдог 38 аппарат байгаа бөгөөд жилд 430,347,000.00₮-ийг зардлыг зарцуулсан байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ӨНДӨР ӨРТӨГТЭЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН СУДАЛГАА

ДҮГНЭЛТ

Судалгаанд нийт 43 эрүүл мэндийн байгууллага хамрагдан, 330 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг ирүүлсэн. Үүнээс

- Гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага нь 100,0 сая төгрөгөөс дээш үнэтэй 163 ширхэг
- Хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага нь 50,0 сая төгрөгөөс дээш үнэтэй 167 ширхэг тоног төхөөрөмжийн судалгааг тус тус ирүүлсэн.

Судалгаанд хамрагдсан нийт эмнэлгийн тоног төхөөрөмжийн

- 171 нь гэрээт засвар үйлчилгээ авдаггүй
- 113 ширхэг тоног төхөөрөмжид сургалт хийгдээгүй
- 152 тоног төхөөрөмжийн гэрээт засвар үйлчилгээ болон сэлбэг хэрэгслийн зардлыг жил бүрийн төсөвт тусгадаггүй
- Гэрээт засвар үйлчилгээ болон сэлбэг хэрэгслийн зардлыг жил бүрийн төсөвт тусгадаг 180 тоног төхөөрөмжийн 36 нь засварын зардлаа жил бүр тогтмол авч чаддаг бол 144 нь засварын зардлаа авч чаддаггүй байна.

Үүнээс үзэхэд дараах үйл ажиллагааг шат шатандаа хэрэгжүүлбэл тоног төхөөрөмжийг хэвийн найдвартай үйл ажиллагаагаар хангах мөн эвдрэл гэмтлийг түргэн шуурхай засварлах боломж бүрдэнэ.

Шийдвэр гаргагчдын түвшинд:

- Эрүүл мэндийн байгууллагаас ирсэн тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээнд шаардагдах зардлыг Эрүүл мэндийн сайдын багцад тусгаж өгөх
- Инженер техникчидыг давтан сургалтад хамруулах

Ашиглагч байгууллага:

- Тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл, засварын зардлыг тооцож шийдвэр гаргагчруу хүргүүлж байх.
- Инженер, техникчидыг тухайн тоног төхөөрөмжийн засварын сургалтад зайлшгүй хамруулах.
- Тоног төхөөрөмжийн баталгаат засварын хугацаан дахь техник үйлчилгээг ханган нийлүүлэгч компаниар хийлгүүлж байх.
- Баталгаат засварын хугацаа дууссаны дараа сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний гэрээг байгуулан ажиллах.
- Хугацаат сэлбэг хэрэгслийг байнга сольж байх.

Ханган нийлүүлэгч компани:

- Тоног төхөөрөмж дээрээ ашиглалт болон засварын сургалтыг зайлшгүй хийж байх.
- Баталгаат засварын хугацаанд төлөвлөгөөт техник үйлчилгээг хийж байх.
- Баталгаат засварын хугацаа дууссаны дараа сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний гэрээг байгуулан ажиллах.